

ЖОРЖ СОРОСЫН НЭЭЛТТЭЙ НИЙГМИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТУХАЙ

Ш.Цог⁴

Сэтгэхүй ба бодит байдал

Нээлттэй нийгмийн үзэл баримтлал нь ертөнцийн талаархи бидний ойлголт угаасаа төгс бус гэдгийг хүлээн зөвшөөрөх дээр үндэслэнэ. Туйлын үнэнийг өмчлөх гэх нь явуургүй санаархал бөгөөд тэр нь өөр үзэл бодолд хүч хэрэглэх замаар л хэрэгжинэ. Хүчирхийллийн тийм хэлбэр бол үзэл бодол, түүнийг илэрхийлэх эрх чөлөөг нухчин дарагч хаалттай нийгэмд л байдаг. Тэгвэл сэтгэхүй, бодит байдлын харилцан хамаарал, харилцан үйлчлэлийн тухай асуудал гарч ирнэ. Нэгэнт төгс мэдлэгт хэзээ ч хүрч чадахгүй учраас нийгмээрээ алдаагаа ухамсарлаж, хүлээн зөвшөөрч чадаж байвал бодит байдлын талаар илүү зөв ойлголттой болж чадна. Сэтгэхүй, бодит байдлын харилцан нөлөөллийн чухам эл харьцааг ухамсарлан ойлгосон үзэл баримтлал дээр үндэслэн өөрийгөө үргэлж сайжруулан хөгжүүлж байх эрмэлзэлтэй нээлттэй нийгмийг байгуулж болно. Нээлттэй нийгэм нь төгс төгөлдөрт хүрэхгүй ч үзэл, бодлын эрх чөлөөг баталгаажуулж, бүтээлч үйл ажиллагаа явуулах өргөн боломж олгодог сайн талтай.

Нээлттэй нийгмийн үзэл баримтлалыг тайлбарлахын тулд, ялангуяа нийгмийн асуудлыг хөнддөгийнх нь хувьд эхлээд сэтгэхүй, бодит байдал хоёрын хоорондын харилцааг авч үзэх ёстой. Бидний ойлголтыг төгс, төгөлдөр бус болгож буй зүйл нь юу болохыг мэдэх шаардлагатай. Мэдлэг бол хүрч, хүртэж болшгүй зүйл биш, гэхдээ бид өөрсдөө идэвхтэй оролцон тоглогч нь болох нөхцөлд шийдвэрийг зөвхөн өөрийн мэдлэг дээр үндэслэн гаргаж болохгүй. Мэдлэг нь тодорхой үйл явдал, баримтад тулгуурладаг бол бидний гаргасан шийдвэрт хамаатайгаар өрнөх үйл явдал бол тодорхой биш, ирээдүйд болох, бидний өнөөгийн шийдвэрээс хамаарах зүйл юм. Тэр нь ирээдүйд биеллээ оллоо ч байгалийн шинжлэх ухааны судлахууныг бүрдүүлэгч тодорхой баримт сэлтээс өөр, бидний бодож, сэтгэж буй зүйлийн нөлөөлөлд орсон байх болно. Бидний бодож буй зүйл нь бидний бодвол зохих зүйлийн зөвхөн нэгээхэн хэсэг байдаг бөгөөд бэрхшээлийн эх сурвалж чухам энд юм.

Сэтгэхүй ба бодит байдлын хоорондын харилцааны асуудал нь хэдийнээс гүн ухаанчдыг эзэмдэж байсан бөгөөд түүнийг өнөөг хүртэл

⁴Ш.Цог - " Нээлттэй нийгэм" хүрээлэнгийн хөтөлбөрийн зохицуулагч

хангалттай ойлгоогүй байна. Гүн ухааны аливаа асуудал эцсийн хөдөлшгүй хариулттай байна гэж байдаггүй, Өөрөөр хэлбэл, асуулт болгон өөр, шинэ асуултыг дэвшүүлэн тавьдаг. Жорж Соросын дэвшүүлж байгаа гол баримтлалыг арай дэлгэрэнгүй авч үзье. Тэрээр бичихдээ миний хэлэх гэсэн гол санаа бол сэтгэхүй ба бодит байдлын хоорондын харилцаа нь эгэж үйлчлэх (reflexive) шинжтэй байдагт байгаа юм. Өөрөөр хэлвэл, бидний бодож буй зүйл нь бидний юун тухай, яаж бодоход ямар нэг байдлаар нөлөөлдөг. Мэдээжээр, энэ нь бодит байдлын үзэгдэл бүрт тийм байхгүй. Байгалийн үйл хөдлөлүүд бидний юу бодохоос үл хамааран өөрийн жамаар явна. Зөвхөн нийгмийн хүрээнд эгэж үйлчлэх шинж (reflexivity) үйлчилдэг ба тэр нь бидний энд ярилцах сэдэв юм.

Эгэж үйлчлэх шинж (reflexivity) нь аливаа үйл явдалд өөрт нь болон түүнд оролцогчдын уг үйл явдлын талаархи ойлголт хоёрын аль алинд тодорхой бус байдлын үр, хөврөлийг бий болгодог. Тэрээр бидний сэтгэхүй, бодит байдал дахь энэхүү тодорхой бус байдлын эх сурвалж төдий бус, бүр огт өөр тодорхой бус байдлын эх сурвалж болдог.

Миний бие энэхүү мэтгэлцээнд тун болгоомжтой хандаж буй. Гүн ухааны гаргалгаа ер нь эцэс төгсгөлгүй хандлагатай байдаг. Эгэж үйлчлэх шинж (Reflexivity) ч мөн адил, битүү тойрог зарчмаар тайлбарлагдана. Төгс, төгөлдөр бус ойлголт нь оролцон тоглогчдын оролцож буй үйл хөдлөлд үр дүнг нь урьдчилан хэлэхийн аргагүй элементийг бий болгодог учраас оролцон тоглогчдод уг үйл хөдлөлийн талаар бий болсон ойлголт нь мөн төгс, төгөлдөр бус байдаг.

Ж. Соросын авч үзэж байгаа өөр нэг чухал ойлголт бол түүний нэрлэснээр “үнэний харилцааны хууль” юм. Мэдлэгийг олж авахын тулд сэтгэхүй, бодит байдал хоёрыг ялган, салгах шаардлагатай гэж тэр үзэж байна. Мэдлэг үнэн илэрхийллүүдээс бүрдэнэ, үнэний харилцааны хуулиар бол аливаа илэрхийлэл зөвхөн бодит үйл явдлаар батлагдаж, түүнтэй яв цав нийлсэн нөхцөлд үнэн болдог. Аливаа илэрхийллийн үнэн эсэхийг зөв тодорхойлохын тулд бодит үйл явдал нь түүнд холбогдох илэрхийллээс огтын хамааралгүй байвал зохино. Илэрхийлэл, бодит байдал хоёрыг үл нэвтрэх ханаар тусгаарласан байх ёстой. Өөрөөр хэлвэл, бодит үйл явдал нэг талд, түүний илэрхийлэл нөгөө талд нь байж, бодит байдал нь тухайн илэрхийллийн үнэн, мөнийг шалгах шалгуур болно.

Гэхдээ эндээс бодит үйл явдал нь түүнд холбогдох илэрхийллээс

байнга тусгаар, түүнээс огт хамааралгүй байна гэсэн дүгнэлт гаргаж болохгүй ба энэ бүхэн мэдлэгийг өөрийн болгоход ийнхүү ялгаж, салгах шаардлагатай гэдгийг хэлж байна. Зарим үед ийм ялгарал зонхилж байдаг бол заримдаа үгүй байдаг байна. Сүүлчийн тохиолдолд бодит байдлыг ойлгоход мэдлэг дутагддаг аж.

Бүдүүлэг нийгэмд хүмүүс өөрсдийн бодол болон тэдний бодолд холбогдох ертөнцийн хооронд ялгаа гаргаж чаддаггүй, тэд өөрсдийн итгэл, үнэмшлийг бий болгож, түүнийгээ бодит байдал мэтээр авч үздэг байна. Жишээ нь, тэд эд, юмсыг ой ухаантайгаар төсөөлж, тийм ой ухаан бий гэдэгт итгэдэг. Сэтгэхүй, бодит байдлын ялгааг хүлээн зөвшөөрөхөд хүрэхээр ертөнцийг үзэх энэхүү үзэлд итгэл алдрах явдал гарна. Үнэн илэрхийллүүд нь худал хуурмагаас ялгардаг бөгөөд ингэснээр мэдлэг бий болох зам нээгддэг байна. Байгалийн аливаа үзэгдлийг амь, сүнстэй холбож үзэх (animism), шашин шүтлэгийн тунхаглах хүч суларч, гүн ухаан, шинжлэх ухааны байр суурь бэхждэг.

Гүн ухаанчид анх сэтгэхүй, бодит байдал хоёрын харилцааны талаар маргалдаж эхлэхэд асуудлын гол нь байгаль, бодит байдлын оршихуй (ontology), түүнийг хэрхэн танин мэдэхийг тайлбарлах (epistemology) явдал байв. Энэ нь гүн ухаанчдыг бодит байдлын шалтгаан, энэ тухай мэдлэгийг идэвхийлэн эрж байхад, харин бодит байдал таньж мэдэгдэхээ идэвхгүй байдлаар хүлээж байдаг гэсэн нэг чиглэлтэй харилцааны хүрээнд сэтгэхэд хүргэсэн байна. Харилцааны асуудалд энэ өнцгөөс хандах хандлага шинжлэх ухааны ололтоор улам бэхэжсэн боловч, шинжлэх ухааны арга зүй судлагдахуунаа шинжлэх ухаанч ажиглагчдын бодол, үйл ажиллагаанд бохирдуулахаас хамгаалсаар уртын урт замыг туулж иржээ.

Харин сэтгэхүй, бодит байдлын хоорондын харилцаа нь дээр дүрсэлсэн шиг нэг чиглэлийн урсгалтай зам биш билээ. Сэтгэдэг оролцогчтой үйл хөдлөл нь судлагдахаа хүлээн идэвхгүй хүлээх бус, харин ч оролцогчийнхоо гаргасан шийдвэрийн хүч, нөлөөнд идэвхжин хөгжиж байдаг байна.

Мэдээжээр, хэн юу бодож буйгаас үл шалтгаалан өрнөх үйл хөдлөл бас байдаг бөгөөд тэдгээр ер бусын зүйл, тухайлбал, гариг эрхсийн хөдөлгөөн нь байгалийн шинжлэх ухааны судлагдахуун болдог. Энэ тохиолдолд сэтгэхүй нь бодит байдлыг ойлгох нэг чиглэлийн, энгийн үүрэг гүйцэтгэж байна. Энд шинжлэх ухааны илэрхийллүүд бодит ертөнцийн үйл явдалд яв цав нийлэх, эсвэл нийлэхгүй байж ч болох боловч аль ч тохиолдолд бодит үйл явдал өөрт холбогдох илэрхийллээс

тусгаар, үл хамааралтай байна. Тиймээс ч байгалийн шинжлэх ухаан гайхамшигт амжилтанд хүрчээ.

Нийгмийн үйл явц нь сэтгэгч (ухамсартай) оролцон тоглогчтой байдгаараа байгалийнхаас ялгаатай. Энд сэтгэхүй, бодит байдлын харилцаа илүү төвөгтэй. Бидний сэтгэхүй үйл ажиллагааг маань удирдаж, үйл ажиллагаа бодит үйл явдалд нөлөөлдөг. Олон хүнийг хамарсан ижил нөхцөл байдалд хүн болгон нэг ижил сэтгэнэ гэж үзэж болохгүй. Гарах үр дүн нь бодитой нэгэн үйл явдал болох бөгөөд тэр нь оролцон тоглогчдын бодлын үнэн, зөвийг шалгах шалгуур болж чадахгүй. Учир нь уг үйл явдал өөрөө түүнд оролцогчдын бодол, үйлдлээс хараат байх болно. Бусад хүчин зүйлээс хараат бус ямар нэгэн шалгуургүйгээр үйл явдалд оролцогчдын бодол мэдлэг болон шалгарч үл чадна. Оролцон тоглогчдын бодол, бодит байдал дээр болсон үйл явдал хоёрын хооронд харилцаа байлаа ч болсон үйл явдлын үр дүнд оролцон тоглогчдын гаргасан шийдвэр нөлөөлсөн байж болно. Тийм болохоор энэхүү харилцаа нь илэрхийлэл, бодит үйл явдал хоёр хоорондоо огт хамааралгүй байх үеийн илэрхийллийн үнэн, зөвийн баталгаа, шалгуур болж чадахгүй. Энэ тохиолдолд сэтгэхүй нь нэг чиглэлийн харилцаанд байж, мэдлэгийн үндэс болохын оронд хоёр давхар үүрэг гүйцэтгэж байна.

Нэг талаас, сэтгэгч (ухамсартай) оролцон тоглогч нь өөрөө оролцож буй тэр үйл явдлыг ойлгох гэж эрмэлзэж байна. Үүнийг идэвхгүй буюу танин мэдэхүйн функц гэж нэрлэе. Нөгөө талаас, оролцон тоглогчид ойлгохыг эрмэлзэж буй тэр үйл явдалдаа оролцож байна. Үүнийг идэвхтэй буюу оролцооны функц гэж нэрлэе. Ингэхээр оролцон тоглогч болон үйл явдал хоёрын хооронд нэг биш, хоёр чиглэлийн харилцаа үүсчээ. Эсрэг чиглэлтэй энэ хоёр функц өөр хоорондоо зөрчилд орж болно. Нэг функцийн үл хувьсагч нь нөгөө функцийнхаа хувьд хувьсагч болно. Хэрэв эдгээр хоёр функц нэгэн зэрэг нэг хувьсагчийг холбоовоос нэг функц нь нөгөөгийнхөө үл хувьсагчийг авна. Энэ харилцан үйлчилгээ нь уг хоёр функцэд нэгэн тодорхой бус элементийг бий болгож байна. Энэхүү элемент нь хоёр функцийг бие биенээс харилцан үл хамааралтай байх нөхцөлд гарч ирэхгүй. Үүнийг миний бие эгэх үйлчлэлийн шинж (reflexivity) гэж нэрлэж байгаа юм. Энэ үгийг би франц хэлний дүрмээс авсан юм. Франц хэлнээ үйл үгийн субъект, объект нь ижил бол уг үйл үгийг рефлексив үйл үг гэдэг ажээ. Je me lave (I wash myself – би өөрөө өөрийгөө угааж байна буюу би биеэ угааж байна).

Ж.Сорос “Эгэх үйлчлэлийн онол”-доо тулгуурлан тодорхой асуудлуудыг доорх байдлаар авч үзэж байна.

Оролцон тоглогч ба ажиглагч. Оролцон тоглогч, байгалийн шинжлэх ухаан судлаач хоёрын байр суурийн ялгааг гаргаж өгөх хэрэгтэй. Энэ нь жирийн нэгэн харьцуулалт биш асуудлыг тодруулж өгөх болно. Байгалийн шинжлэх ухаанчид орчлон, ертөнцийг тэдний сэтгэхүйгээс үл хамаарах зүйл гэж үздэг. Тэдний илэрхийлэл өөрийн нэгэн ертөнцөд хамаарч, бодит үйл явдлууд мөн өөрийн ертөнцөд хамаарна гэж тэд үздэг. Тэгэхээр энэ тохиолдолд зөвхөн нэг чиглэлийн урсгалын зарчим илэрхийлэл, үйл явдлын хооронд үйлчлэх боломжтой.

Чухамхүү энэ нь л шинжлэх ухааны аливаа илэрхийллийн үнэн, зөвийг шүүх шалгуур болох үйл явдлын гол шинж чанар юм. Тэр нь мөн үйл явдлуудыг элдэв дүгнэлт хийхийг оролдсон илэрхийллийн эсрэг дархлалтай гэж үзнэ. Хэрэв эрдэмтэн хүн бодит байдлын талаар үндэслэл сайтай, зөв дүгнэлт хийе гэвэл түүний талаар мэдлэгтэй болох ёстой.

Ухамсартай оролцон тоглогчдын хувьд ийм биш. Тэд үйл явдалд шууд оролцох явцдаа өөрсдийн болон бусад оролцогчдын шийдвэрт нөлөөлөхүйц элдэв үндэслэл, томъёолол дэвшүүлж байдаг. Харин тэдгээр илэрхийллүүд нь уг үйл явдлын мөн чанарыг яв цав илэрхийлэх албагүй, оролцон тоглогчдын сэтгэхүйг тодорхойлсон харилцаа байхгүй байх нөхцөлд ингэх боломж ч үгүй юм. Гэхдээ л тэдгээр илэрхийлэл үйл хөдлөлийн өрнөлд ямар нэг хэмжээгээр нөлөөлөх бөгөөд уг үйл явдлын талаархи ойлголт төгс, төгөлдөр байж чаддаггүйгээс болж, эцсийн үр дүнг төсөөлж байснаас өөр зүгт хандуулж болно. Энд 2 талын үйлчлэлтэй механизм үйлчлэх бөгөөд оролцон тоглогчдын бодол болон үйл явдлын өрнөлийн аль алиныг хараат байдалтай болгоно. Сэтгэхүй, бодит байдал хоёрын аль алинд нь өөрчлөлт оруулдаг энэхүү үйл явц бол түүхэн ач холбогдолтой.

Түүхэн үйл явц. Хоёр талын үйлчлэлтэй механизм нь тэр болгон түүхэн үйл явдалд хүргэхгүй. Ингэхүйц хүчин чадал түүнд үгүй. Үйл явдлын үр дүн төсөөлж байснаас төдийлөн хазайхгүй байх тохиолдол их байдгийн дээр үр дүнгийн зөрөө гарлаа гэхэд тэр нь оролцогчдын төсөөлөлд мэдэгдэхүйц өөрчлөлт оруулах хэмжээнд байдаггүй. Энд гол нь энэхүү зөрөө ямар нэгэн эрчтэй үйл явцыг хөдөлгөөнд оруулж буй нь илүү сонирхолтой юм.

Тэрхүү эрч хүчийг ойлгох түлхүүрийг оролцон тоглогчдын шийдвэр гаргахдаа харгалзан үзвэл зохих дүгнэлтийн хүчин зүйлийн

хүрэнээс эрвэл зохино. Ийм дүгнэлтгүйгээр тэд шийдвэр гаргах боломжгүй гэдгийг бид дээр хэлсэн. Дүгнэлт хийхэд бодит үр дүн, төсөөлөл хоёрын зөрүү эерэгээр юмуу сөргөөр нөлөөлнө. Эерэг нөлөөлөл нь анхны дүгнэлтийг бэхжүүлж өгснөөр цаашид мөн эерэг нөлөөлөл үзүүлэх боловч уг үйл явц цааш хязгааргүй өрнөх боломжгүй, учир нь анх хийсэн дүгнэлт дахин дахин нотлогдсоор байх авч бодит байдал тэрхүү төсөөллийн хэмжээнд хүртэл өрнөх чадваргүй болох тэр цэгт тулж очиж болно.

Оролцон тоглогч бүр өөр өөрийн дүгнэлттэй байдаг боловч, ялангуяа санхүүгийн зах зээлийн хувьд аль нэг давамгайлах дүгнэлт, байдлын талаар ярьдаг. Дээр хэлсэнчлэн, эхэн үед үр дүн (бодит байдал) дүгнэлтийг нотлож болох авч яваандаа үйл явдлын өрнөлтөөр дүгнэлтийн үйл явдалд нөлөөлөх чадвар буурсаар бодит байдлыг төсөөллийн хэмжээнд аваачиж чадахгүйд хүрч болно. Бодит байдал, төсөөлөл хоёрын ялгаа ихсэхийн хирээр давамгайлж буй дүгнэлтийг хадгалж үлдэх улам бүр төвөгтэй болно. Оролцон тоглогч өөрийн хийсэн дүгнэлтэд эргэлзэх буюу түүнээс татгалзахад хүрвэл түүний эсрэг чиглэлд хандсан эрчээ авах үйл явц хөдөлгөөнд орж эхэлнэ. Давамгайлж буй дүгнэлт (өөрийгөө нотлох) үйл явцаас хамааралтай болох тутам үр дүн, төсөөлөл хоёрын ялгаа ихэсч, энэ хирээр эсрэг үйл явц өрнөх магадлал ихэснэ.

Эгэх үйлчлэлтэй (Reflexive) үйл явц цаг, хугацааны эрхэнд өрнөдөг. Тухайн үед хүмүүсийг өөрсдийн шийдвэрээр дамжин тодорхой үр дүнд хүрэх төсөөлөл удирдаж байдаг. Тэр үр дүн нь хүмүүсийн төсөөлөлд өөрчлөлт оруулж, тэр нь өөр шинэ үр дүнд хүргэх дараагийн шийдвэрийг өөрчлөх тул ийм замаар өрнөх үйл хөдлөл тодорхой хугацаа шаарддаг.

Танин мэдэхүйн болон оролцооны функцүүд нь бие биеэсээ цаг хугацаагаар тусгаарлагдсан байх тул өөр хоорондоо харилцан нөлөөлдөггүй гэж үзэж болох юм. Оролцон тоглогчийн төсөөлөл бол хэзээд байж байдаг бөгөөд санаандгүй ямар нэгэн үр дүн түүнд хэзээ ч нөлөөлж болно.

Энэ үндэслэгээг оролцон тоглогчийн сэтгэн бодох үйл ажиллагаа гадны аливаа үйл явдлаар хязгаарлагддаггүй, тэдний сэтгэхүйд гарах өөрчлөлт гадны үйл явдлаас заавал хамаарах учиргүй гэдгээр няцааж болох юм. Ялангуяа хүмүүс өөрсдийн тухай юмуу бие биеийн тухай бодох үед дээрх хоёр функц зэрэг үйлчилж байдаг. “Би чамд хайртай”, “Тэр миний дайсан” гэсэн илэрхийллийг авч үзвэл, уг санааг

илэрхийлэнгүүт уг илэрхийлэл тэр дороо хандсан хүндээ үйлчилж эхэлнэ. Хүнд өөрийн нь сэтгэхүйг өөрчлөх бодол орж ирвэл түүний үйлчилгээ нь үүнээс ч хурдан байх нь ойлгомжтой. Энэ нөхцөлд цаг, хугацааны тусгаарлах үйлчилгээ байхгүй, хоёр функцийг маш богино, хурдан холбоос холбож байна. Хүний бодол өөрчлөгдвөл, үйлдэл мөн өөрчлөгдөх бөгөөд уг өөрчлөлт нь гадны нөхцлөөр тодорхойлогдохгүй.

Ийм өөрчлөлт гарах нь хүний сэтгэхүйд шууд, гадна ертөнцөд шууд бусаар нөлөөлдөг. Эгэх үйлчлэл (Reflexivity)-ийн оролцон тоглогчийн бие төрх, үнэ цэнэ, төсөөллийг бүрэлдүүлэхэд үзүүлэх нөлөөлөл нь үйл явдлын өрнөлд нөлөөлөхөөс хавьгүй өргөн хүрээтэй байдаг. Өргөн утгаар бол хувь хүн, түүний зан төлөв нь эгэх үйлчлэлийн (reflexive) замаар бүрэлдэн тогтдог. Эхэн үедээ өөрөөсөө хүчээ авч, аажмаар өөрийгөө дарж, үгүй болгогч тэр үйл явц ховор тохиолдох боловч тохиолдох юм бол түүхэн ач холбогдолтой үзэгдэл болдог.

Оролцон тоглогчийн өөрийн болон бусдын тухай үзэл, бодлын тодорхой бус байдал нь болж буй үйл явдалд тодорхой бус хүчин зүйлийг бий болгодог. Гэрлэлтийг авч үзье. Энэ үйл явдалд хоёр сэтгэгч, оролцон тоглогч оролцож байгаа бөгөөд тэдний сэтгэн бодох үйл нь тэдний сэтгэхүй, мэдрэмжээс тусдаа, тэдгээрээс үл хамаарах ямар нэгэн бодит байдал руу чиглэсэн биш ажээ. Нэгнийх нь бодол, мэдрэмж нөгөөгийнхөө харьцаа, үйл хөдлөлд нөлөөлнө. Энэ мэдрэмж, үйл хөдлөл нь гэрлэх үйл явц өрнөх тутам бүх зүйлд өөрчлөлт оруулна.

Сэтгэн бодох үйл ажиллагаа гадаад ертөнцийн үйл явдал чиглэгдсэн байлаа ч тэдгээр үйл явдал нь үнэн хэрэгтээ оролцон тоглогчийн бодлын дагуу өөрчлөгдөх байдлаар өрнөхгүй. Санхүүгийн зах зээлийг аваад үзье. Хөрөнгө оруулалтын утга, учир бол ирээдүйг урьдчилан төсөөлөх буюу авч үзэх явдал юм. Гэтэл хөрөнгө оруулагчийн тухайн нэг хувьцаанд төлөх үнэ компанийн бэл бэнчинд олон замаар нөлөөлөх тул ирээдүй тодорхой бус ажээ. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн төсөөлөл нь урьдчилан харах гээд байгаа тэр ирээдүйд нөлөөлнө. Энэ нь санхүүгийн зах зээл дэх үнийг туйлын тодорхой бус болгодог.

Нийгмийн үйл явдал болгон эгэж үйлчлэх (reflexive) шинжтэй байдаггүй бол түүхэн үйл явдал ихэнхдээ эгэх үйлчлэлтэй (reflexive) байдаг байна. Үнэхээр эгэх үйлчлэл (reflexivity) л чухамдаа үйл явдлыг түүхэн ач холбогдолтой болгодог гэж үзэж болно. Бид хоёр функц мэдэгдэхүйц хэмжээгээр харилцан үйлчлэлд ордоггүй жирийн үйл явдал, тийм үйлчлэлд ордог түүхэн үйл явдал гэж ялган үзэж болно. Жишээ авъя. Ажил ругаа унаагаар явах нь жирийн л нэг үзэгдэл. ЗХУКН-ын

XX Их хурал дээр Никита Хрушевын хэлсэн үг бол түүхэн үйл явдал. Үнэхээр түүхэн үйл явдал нь зөвхөн ертөнцийг өөрчлөөд зогсохгүй, ертөнцийн талаархи бидний ойлголтыг өөрчилдөг, энэхүү шинэ ойлголт нь эргээд үйл явдлын өрнөлтөд урьдчилан хэлэхийн аргагүй өөр маягаар нөлөөлдөг. Сталины гэмт хэргийг илчилснээр Хрушев хүмүүсийн ойлголтод эргэлт гаргасан ба хэдийгээр коммунист дэглэм тэр даруй өөрчлөгдөөгүй ч түүний хэлсэн үг урьдчилан хэлэхийн аргагүй үр дагавартай байсан: 30 жилийн дараа ил тод байдлын тэргүүн эгнээнд явагсдын үзэл, бодол Хрушевын үед төлөвшин бүрэлджээ.